



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 08 сарын 28 өдөр

Дугаар

1113

Чойр

Аймгийн тооллогын комиссыг
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6.а, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2 дахь хэсэг, Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2018 оны 76 дугаар тогтоол, Хүн ам, орон сууцны тооллогын улсын комиссын 2018 оны 02 дугаар тогтоолын 1.1 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүн ам, орон сууцны улсын 2020 оны ээлжит тооллогыг зохион байгуулж явуулах аймгийн тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА:
ТООЛЛОГЫН КОМИССЫН
ОРЛОГЧ ДАРГА:
ГИШҮҮД:


Аймгийн Засаг дарга
Статистикийн хэлтсийн дарга
Аймгийн ИТХ-ын Нарийн бичгийн дарга
Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Төрийн захиргааны, удирдлагын хэлтсийн дарга
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Цэргийн штабын дарга
Говьсүмбэр аймаг дахь Автотээврийн төвийн дарга
Боловсрол, соёл, урлагийн газрын дарга
Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
Онцгой байдлын газрын дарга
Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
Хөдөлмөр, халамжийн, үйлчилгээний газрын дарга
Цагдаагийн хэлтсийн дарга

Эрүүл мэндийн газрын дарга
Байгаль орчин, аялал,
жуулчлалын газрын дарга
Гадаадын иргэн, харьяатын
газрын Говьсүмбэр аймаг дахь
мэргэжилтэн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх
газрын дарга
Сүмбэр сумын Засаг дарга
Статистикийн хэлтсийн ахлах
мэргэжилтэн

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

2. Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын бэлтгэл ажлыг сайтар ханган, төвлөсөн хугацаанд чанартай зохион байгуулж ажиллахыг комиссын гишүүдэд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



БАТСУУРЬ



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 5/04

Чойр

□ Д.Оюунцэцэгийг ажилд томилох тухай □

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 19.3, 19.6.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Тус хэлтсийн гэрээт ажилтан Д.Оюунцэцэгээр 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс нягтлан бодогчийн ажлыг хавсруулан гүйцэтгүүлсүгэй.

Ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг гэрээт ажилтны сарын үндсэн цалингийн 25 хувиар тооцож, сар бүр олгохыг нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг хуулийн хугацаанд тайлагнан, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Д.Оюунцэцэгт үүрэг болгосугай.

ДАРГА



Л.МӨНГӨНЦЭЦЭГ